

**АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**  
**/ Оны эхний 2 сард /**

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 0.9 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 5.2 %-иар давсан нь урьд оныхоос 0.4 тэрбумаар доогуур байна.

Асгат, Дарьганга, Мөнххаан, Наран, Онгон, Сүхбаатар, Түвшинширээ, Халзан, Түмэнцогт сумдын төсвийн орлогын төлөвлөгөө нь 5.4-205.7 хувиар давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 0.7 тэрбум төгрөг болжээ.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 36.2 тэрбум төгрөгт хүрч, 2011 оны жилийн эцсээс 1.1 тэрбум төгрөгөөр буюу 3.1 %-иар өсчээ.

Иргэдийн төгрөгийн хадгаламжийн үлдэгдэл 17.8 тэрбум төгрөг болж, 2011 оны жилийн эцсээс 1 тэрбум төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Малын онд оролт: Энэ онд 2081.4 мянган мал онд орж байгаа бөгөөд эхний 2 сард оны эхний малын 0.1 хувь болох 2.3 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.9 хувьтай байна.

Нийт хорогдсон малын 54.9 хувь нь ямаа, 37.7 хувь нь хонь эзлэж байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл: Түмэнцогт, Мөнххаан, Асгат, Түвшинширээ, Баяндэлгэр сумдын оны эхний малын 0.9-0.1 хувь болох 2.1 мянган мал хорогдоод байгаа нь нийт хорогдлын 90 гаруй хувийг эзэлж байна.

Наран, Халзан, Эрдэнэцагаан сумд мал хорогдоогүй гэсэн мэдээ өгсөн.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 5.6 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум төгрөгөөр буюу 11.2 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Аж үйлдвэрийн борлуулалт оны үнээр 19.9 тэрбум болж, өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар доогуур байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн болон хэвийн боов, нүүрс, цайрын баяжмалын үйлдвэрлэлт нэмэгдсэн.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс оны эхний 2 сард 3.1 хувиар өссөнд холбоо, боловсролын үйлчилгээний салбараас бусад бүх бүлгийн барааны үнэ тариф 0.1-9.5 хувь болтлоо өссөн нь нөлөөлжээ

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** 227 эх амаржиж, 229 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 114 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 18-аар олон байгаа бөгөөд гепатит, салхинцэцэг, тэмбүү, трихоминиаз зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 892 болж, өмнөх оны мөн үеэс 101-ээр буурсан байна. Ажилгүй иргэдийн 76.1 хувь нь 16-34 насны залуучууд, 40.5 хувь нь бүрэн дунд, 21.3 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** Бүртгэгдсэн гэмт хэрэг 34 байгаа нь урьд оны мөн үеэс 12 хэргээр буюу 54.5 хувиар өсчээ. Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 8 хүн гэмтэж осолдсон нь урьд оны мөн үеэс доогуур байна. ААНБ, иргэдэд 9.7 сая төгрөгийн хохирол учирсны 7.0 сая төгрөгийг нөхөн төлүүлжээ.

Гэмт хэрэгт 23 хүн сэжиглэгдсэний 30.4 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 471 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс доогуур байгаа бөгөөд баривчлуулсан хүний тоо урьд онуудын мөн үеэс 8.6 хувиар өссөн байна.



**АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**